

ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙН ГАДААДАД ЗОРЧИХ ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

LEGAL REGULATION OF EXECUTION OF THE DECISION TO SUSPEND THE PAYER'S RIGHT TO TRAVEL ABROAD



Б.Хүслэн

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
541 дүгээр дамжааны сонсогч*

Товч утга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаан дахь төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааны онолын хувьд судалж, эрх зүйн зохицуулалтын онцлог, практикт суурилан, хэрэгжилтэд тулгарч буй зарим асуудлыг судлан, цаашид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар судлаачийн зүгээс шинэ санал боловсруулсан.

Түлхүүр үгс: Хүний эрх, гадаадад зорчих эрх, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээ, хууль эрх зүйн орчин, нийгэм, төлбөр төлөгч.

Abstract: Theoretical research in court decision enforcement will be studied in theory. The specifics of the legal regulation will be analyzed based on practical results. The some problems of restraining suspend debtors right to travel abroad will be identified. And proporsals will be developed.

Keywords: Human rights, right to free movement out of the country, suspend the rights of debtor to travel abroad, legal framework, society, debtor.

Төлбөр төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны практикын тулгамдсан асуудлыг хөндөхөөс урьтаж хүний эрхийн талаарх суурь ойлголтыг авж үзэх нь зүйтэй юм. Аливаа эрх зүйн зохицуулалт нь бүгд утгаа хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэгдэх ба түүнийг хязгаарлах арга хэмжээ нь онолын болоод зайлшгүй шаардлагаас урган гарсан байх зүй тогтолтой.

Хүний жам ёсны эрхийн судлагдахуун нь хүн хэмээх бодгалаас салгаж үл болох ойлголт бөгөөд хүн байх мөн чанарыг илэрхийлдэг билээ. Эдгээр нь хувь хүнд заяагдсан давтагдашгүй өгөгдлөөс үл хамааран хүн бүрт ижил тэгш заяагдсан

зүйл юм. Иймд хүний жам ёсны эрхийн салшгүй нэг хэсэг болох чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлах хүний мөн чанарт нөлөөлөх агуулгыг өөртөө багтаах тул анхааралтай хандаж нь чухал.

Тэгвэл “Хүний эрх” гэж юу вэ? Хүний эрх (англи. Human right, орос. Права человека) гэдэг нь агуулгын хувьд та бидний төсөөлж буйгаас ч илүү өргөн цар хүрээтэй бөгөөд хүний төрөлхийн шинжээс урган гарч, хувь хүний нийгэмд оршин тогтнох үндсийг тодорхойлдог ухагдахуун гэж ойлгож болно. Үүнээс үзэхэд хүний эрх хэмээгч нь тэдгээрийн нийтлэг шинжийг илэрхийлж, хамтран амьдрах хэм хэмжээг тодорхойлох, чөлөөтэй байх боломжийг бий болгох ёстой.

Орчин үед хүний эрхийг дараах үндсэн шинж чанарыг агуулдаг гэж үзэх болсон. Үүнд: Түгээмэл, хүнээс салшгүй байх, харилцан хамааралтай, хуваагдашгүй байх, тэгш бөгөөд ялгаварлан гадуурхахгүй байх, эрх, үүргийн нэгдэл байна.

Хүний эрх нь хүн бүрд хамаатайн адил хүн бүрийн үүрэг хариуцлага байна. Хүн бусадтай харилцахдаа, нэг бүлэг нөгөө бүлэгтэйгээ харилцахдаа эрх, үүргийн харилцаанд ордог. Ялангуяа олон улсын хүний эрхийн хуульд зааснаар төр нь хүний эрхийг хангаж, хамгаалах үүрэг хариуцлагыг өөртөө хүлээдэг.¹⁷⁹ Эдгээр шинжүүд нь хэдийгээр хүний эрхийн халдашгүй байдлыг тодорхойлж байгаа боловч хүний эрхийг хязгаарлах нийтлэг шинжийг ч мөн адил дурджээ. Тухайлбал хууль, эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн хүний эрхийг хязгаарлахад хүргэх, зарим эрхийг зөрчсөн нь зарим эрхийг хязгаарлах нөхцөл болдог. Мөн хүний эрхийг хамгаалах зорилгын хүрээнд бусад эрхийг хязгаарлах боломж олгодог зэрэг хүний эрхийг хязгаарлах шаардлагыг тодорхойлжээ. Иймд төлбөр төлөгч буюу эрх зүйн зөрчил үйлдэгчийн зорчих эрхийг хязгаарлах асуудал зайлшгүй шаардлагаас урган гарсан ойлголт болох нь харагдаж байна. Гэхдээ хэрхэн яаж хязгаарлах арга журмыг нарийвлан судлах шаардлагатай.

Тус арга хэмжээг үүслийн хувьд авч үзвэл “Ромын сенат Октавианд хүндэт Август нь МЭӨ 27 онд Ромын эзэнт гүрнийг байгуулахдаа Египетийн Ромын шинэ мужийг хаант засаглалын эрх мэдэлд шилжүүлж, сенаторуудыг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ийш, тийш зорчихыг хориглодог байсан.”¹⁸⁰ Энэ үеэс дэлхийн түүхэнд зорчих эрхийг нь хязгаарлах гэдэг ухагдахуун үүссэн. Харин манай улсын хувьд хүний зорчих эрхийг хязгаарлах арга хэмжээг авч эхэлсэн түүхэн уламжлалын хувьд XI-XIII зууны үеийн хууль цаазын сурвалж бичгүүдэд тухайлбал Их засаг хуульнаа¹⁸¹ тусгагдсан байдаг аж.

¹⁷⁹ Агар-Эрдэнэ.Г нар., Хүний эрхийн товч тайлбар., УБ.,2013., 229 дэх тал.,

¹⁸⁰ Cassius Dio., *Roman History.*, Book LV, 26.

¹⁸¹ Их засаг хууль (2023). www.wikipedia.org. Татаж үзсэн: 03.18.2023.,

Манай улсын тухайд харьцангуй сүүл үед буюу 1926 оны Засгийн газрын 26 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Шүүн таслах газраас аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хуулийн хорин зургаадугаар зүйлд “Аливаа хэрэгтэнг шүүн таслах газраас түр буюу байцаагч түшмэдүүдэд ирүүлэхэд эрх биш бэлэн байлгах аргад” сууж буй орон нутгаас зайлж үл гарч болно хэмээн гарын үсэг зурсан батлах хуудас авдаг байжээ¹⁸². Энэ нь нутаг заах хариуцлага, хан аймагт цөлөх хил давуулан цөлөх зэргээс нь мөн чанарын хувьд дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхээс гадна, шийтгэх ажиллагаанд саад учруулж болзошгүй, оргон зугтахыг таслан зогсоох зэрэг одоогийн гадаадад зорчих эрхийг түдгүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинж чанар, зорилтыг агуулсан. Эдгээрээс үзэхэд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрх буюу эрх хязгаарлах арга хэмжээ нь анх эрүүгийн эрх зүйд бий болсон байх магадлалтай бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, гэмт хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдол бүхий түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор прокурорын саналын үндэслэн шүүхээс авч хэрэгжүүлж буй хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ болон хөгжиж ирсэн байна.

¹⁸² Сумьяабаатар.Б., Ташкент., 2003., Чингис хаан “Их засаг” хэсэг шинээр олдов., Cultural exchange between East and West“ Олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлээс дам ишлэв.

Өнөөдөр Монгол Улсын иргэний эрхийг тэр дундаа гадаад зорчих эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг дараах зайлшгүй шаардлага буюу хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж байна.

ҮНДЭСЛЭЛ - 01	НӨХЦӨЛ - 01	ХУГАЦАА - 01
1. Гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол. 2. Эрүүгийн ял шийтгүүлсэн бол. 3. Хуулиар тогтоосон төрийн нууцыг мэдэж байгаа болон түүнийг шууд хариуцаж байгаа албан тушаалтан цагаачлах хүсэлт гаргасан бол.	Энэхүү үндэслэл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлд "яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ" гэж заасан байдаг.	1. Сэжигтэн, яллагдагчаар татагдсан гэмт хэргийг шийдвэрлэх хүртэл 2. Шийтгүүлсэн ялыг эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх хүртэл. 3. Уг ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн өдрөөс хойш 3 жилийн дотор;
ҮНДЭСЛЭЛ - 02	НӨХЦӨЛ - 02	ХУГАЦАА - 02
1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол. 2. Хуурамч, бусдын паспорт, баримт бичиг ашигласан, эсхүл 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортаа гэмтээсэн, хаяж үрэгдүүлсэн бол.	Энэхүү үндэслэл нь Зөрчлийн тухай хуульд арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх, эсхүл хөрөнгө орлого, хохирлын тодорхой хувиар тооцсон торгох шийтгэлийн хэмжээ арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд холбогдогчийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлж болно хэмээн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.5 дугаар зүйлд заасан байдаг. Хуурамч, бусдын паспорт, баримт бичиг ашигласан эсхүл 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортаа гэмтээсэн хаяж үрэгдүүлсэн гэх үндэслэл нь бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага "Монгол Улсын иргэний гадаадад хувийн хэргээр зорчих эрхийг түр түдгэлзүүлэх болон иргэний баримт бичигт бүртгэл хөтлөхөд хориг тавих, цуцлах бүртгэл хөтлөх журам"-аар үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зохицуулсан байна.	1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэрт заасан хугацаагаар; 2. 2 жил хүртэл хугацаагаар.
ШҮҮГЧ	ПРОКУРОР	ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлд "яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ" гэж заасан байдаг.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 187.1.1-д заасан тогтоолын биелэлтийг хойшлуулсан гадаадад зорчих, цагаачлахыг хориглож, Хоригоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, Гадаадын иргэнийг Монгол улсын хилээр гарахыг түдгэлзүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавина. Мөн зөрчлийн тухай хуульд арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх, эсхүл хөрөнгө орлого, хохирлын тодорхой хувиар тооцсон торгох шийтгэлийн хэмжээ арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд холбогдогчийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлж болно гэж заасан байдаг	- Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэхэд нийслэлд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт цагдаагийн байгууллага хяналт тавих буюу - Түдгэлзүүлсэн болон хориг тавьсан цуцалсан бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын бүртгэл хяналтын ахлах байцаагч хөтөлнө.
	Энэхүү хүснэгтэд Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээ буюу шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хилийн хориг тавих арга хэмжээний талаар дурьдаагүй болно.	Цагдаа, Тагнуулын байгууллага, Авилгатай тэмцэх газар зэргээс...

Хүснэгт: 1. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх тухай

Дээр дурдсан үндэслүүдээс өөр бусад үндэслэлээр Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг хязгаарлахыг хориглоно¹⁸³ хэмээн Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуульд заасан байдаг. Энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон зөрчил шалган шийдвэрлэх

¹⁸³ Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хууль., УБ.,1993., Төрийн мэдээдэл эмхэтгэлийн №2., 5 дугаар зүйлийн 1 дахь хэсэг.

ажиллагааны хүрээнд Монгол улсын иргэний гадаадад зорчих эрхийг хязгаарлах нь нийтийн ашиг сонирхлыг хангах зорилгоор авч буй арга хэмжээ юм. Харин хувийн эрх зүйн буюу хувь хүний эрх, ашиг сонирхлыг хангах зорилгоор хүний эрхийг хязгаарлах ажиллагаанд хууль тогтоогч болон эрх бүхий байгууллагаас хойрго хандах эрсдэл байна. Учир нь нийтийн эрх ашгийг хувь хүний эрх ашигтай харьцуулан авч үзэлтгүй хэдий ч ардчилсан эрх зүйн тогтолцооны үндэс нь хувь хүний эрх байдаг гэдгийг санах хэрэгтэй. Иймд хувийн эрх зүйн салбарт ч шаардлагатай тохиолдолд иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх хэрэгцээ үүсдэг. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хуулийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу “гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол” гэх заалт нь төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцаа нь иргэний хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн буюу эрүүгийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс үүснэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн харилцааны элемент нь агуулга, субъект, объект гэсэн хоорондоо холбоо бүхий бүтэцтэй байдаг.¹⁸⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа¹⁸⁵-ны төрлүүдээс иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны албадлагын арга хэмжээний нэг болох төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа өөрийн гэсэн онцлогтой.

Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр төлөгч буюу төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт дурдсан иргэн, хуулийн¹⁸⁶ этгээдийг нэрлэдэг ба шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд нь эсрэг, тэсрэг ашиг сонирхол бүхий боловч хоорондоо харилцан хамааралтайгаар ажиллагаанд оролцдог. Үүнээс дараах тодорхойлолтыг гаргах нь зүйтэй бөгөөд төлбөр төлөгч иргэн гэдэг нь гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, төлбөр төлөгч хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан гэдэг нь гүйцэтгэх баримт бичигт заасан хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд, гүйцэтгэх удирдлага, төлөөлөн

¹⁸⁴ Дашзэвэг.Б., Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй., УБ., 2003., 103 дахь тал.

¹⁸⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль., УБ., 2017., Төрийн мэдээлэл эмхэтгэлийн №24., 6 дугаар зүйлийн 6.1., “Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дараах ажиллагаа хамаарна. Иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, Захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, Зөрчлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хамаарахаар хуульчилсан.

¹⁸⁶ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль., УБ., 2017., Төрийн мэдээлэл эмхэтгэлийн №24.

удирдах зөвлөлийн дарга, нэг хувьцаа эзэмшигч байгаа бол тухайн хувьцаа эзэмшигчийг ойлгоно.¹⁸⁷

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэгдэх явцад төлбөр авагч нь шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр хүсэлт гаргасан, шийдвэрийг шүүгч даруй биелүүлэх шаардлагатай гэж үзсэн бол шүүгч албадан гүйцэтгүүлэх захирамж гарган захирамж гарснаас хойш 7 хоногийн дотор уг захирамж, шүүхийн шийдвэр, шаардлагатай бусад материалыг хавсарган шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх захирамж, гүйцэтгэх хуудас, зардлын гэрээ төлсөн эсэхийг шалган авч ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд зааснаар явуулна. Төлбөр төлөгч нь иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцохдоо эдлэх эрх¹⁸⁸, хүлээх үүрэг¹⁸⁹, хариуцлага¹⁹⁰, холбогдох хуулийн зүйл, заалтай танилцан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрт заасан мөнгөн төлбөр болон хөрөнгийн шинжтэй шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн удирдах албан тушаалтны гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх санал гаргаж, шийдвэрлүүлнэ.

¹⁸⁷ Өнөрцэцэг Ч., УБ., 2020., Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарт зориулсан гарын авлага., 82 дахь тал.

¹⁸⁸ Төлбөр төлөгчийн эрхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлд тогтоосон байдаг ба- Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах хугацааны санал гаргах, хураах хөрөнгийн талаар хүсэлт гаргах, төлбөрт хураагдсан өөрийн өмчлөл, эзэмшлийн хөрөнгийг шинжээчийн тогтоосон үнээс багагүй үнээр худалдан борлуулах хугацаа тогтоолгох, дуудлага худалдаа явагдахаас өмнө бусдад гэрээний үндсэн хөрөнгөө худалдан борлуулах, дуудлага худалдаанд оролцох, албадлагын арга хэмжээ хянуулах, хүчингүйд тооцуулах хөрөнгийн үнэлгээ болон эрх хөндөгдсөн асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрх хэмээн Өнөрцэцэг Ч., УБ., 2022., Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дараалал, эрх зүйн зохицуулалт., 43 дахь талд тодорхойлсон байдаг.

¹⁸⁹ Төлбөр төлөгчийн үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлд тогтоосон байдаг ба- Гүйцэтгэх баримт бичигт заасан тодорхой үүргийг биелүүлэх, тодорхой үйлдэл хийх эсхүл түүнээс татгалзах, эд хөрөнгө, мөнгө шилжүүлэх, оршин суугаа /байгаа/ хаягаа өөрчилсөн бол шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэх, хөрөнгийн мэдүүлэг өгөх, хөрөнгийн өөрчлөлтийг даруй мэдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчээс тавьсан шаардлагыг биелүүлэх, төлбөрт хураагдсан хөрөнгөнд нэвтрүүлэх, шинжээч ажиллах нөхцөлийг хангах, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг нөхөн төлөх үүргийг хүлээнэ хэмээн мөн тэнд тодорхойлсон байдаг.

¹⁹⁰ Төлбөр төлөгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулах зорилгоор шийдвэр гүйцэтгэгчийг дуудсан цаг, оршин суугаа хаяг дээрээ байхгүй, хөрөнгийн мэдүүлэг буруу гаргах, эд хөрөнгөө нуун дарагдуулах үед Эрүүгийн хуулийн 21.7 дугаар зүйлд зааснаар хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсвэл зургаан сараас нэг жил хүртэл зорчих эрх хязгаарлах, эсвэл зургаан сараас нэг жил хүртэл хорих ялаар шийтгэдэг.

Зөрчлийн тухай хуулийн 15.27 дугаар зүйлд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч бус этгээд төлбөр төлөгчийн хөрөнгийн талаарх мэдүүлгийг зориуд худал мэдүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгодог байна.

Тавин сая төгрөгөөс дээш хөрөнгийн шаардлага бүхий эсхүл тэжээн тэтгэх үүргээ **3 сараас** дээш хугацаагаар биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг тогтоосон хугацаанд үүргээ биелүүлээгүйгээс гадна санаатайгаар зайлсхийсэн, хөрөнгөө нуун дарагдуулсан, гадаад улсад зорчиж болзошгүй үндэслэл зэрэг үндэслэл¹⁹¹ байгаа тохиолдолд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай санал гаргахдаа анхаарах асуудлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт: 2 “Шийдвэр гүйцэтгэгч санал гаргахдаа анхаарах асуудал”

Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх санал гаргахад анхаарах асуудал:	
Нэг төлбөр төлөгчид холбогдох хэд хэдэн гүйцэтгэх баримт бичиг байгаа бол:	Нэг гүйцэтгэх баримт бичигт холбогдох хэд хэдэн төлбөр төлөгчийн үүрэг тодорхойгүй бол:
1. Тэдгээрийн нийт төлбөрийн хэмжээг нэгтгэх. 2. Хэд хэдэн гүйцэтгэх баримт бичиг нь өөр өөр тойрогт бүртгэлтэй бол саналыг нэгтгэн хүргүүлнэ. 3. Нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх гүйцэтгэх баримт бичгийн мэдээлэл, саналыг Шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлнэ.	1. Тэдгээрийн нийт төлбөр төлөгчдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх санал гаргана. 2. Хэрэв гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчийн гүйцэтгэх үүрэг тодорхой заасан, уг үүрэг нь албадлагын арга хэмжээ тогтоолгох шаардлагад нийцэхгүй бол санал гаргахгүй.¹⁹²

Ерөнхийдөө төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь:

1. Шийдвэр гүйцэтгэгч хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд санал гаргах
2. Ахлах шийдвэр гүйцэтгэгч саналыг хянах
3. Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч санал шийдвэрлэх гэсэн үе шаттайгаар явагддаг.

Шийдвэр гүйцэтгэх албаны эрх бүхий албан тушаалтан нь Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг, төлбөр төлөгчийн мэдээллийн хамт Хил хамгаалах ерөнхий газарт хүргүүлэх бөгөөд төлбөр төлөгч гадаадын иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахдаа гадаадын иргэн, харьяатын газарт мэдэгдэж, шийдвэрийн биелэлтийг хангуулж, нэгдсэн тоо бүртгэлд бүртгэн албадан гүйцэтгэх арга хэмжээг гүйцэтгэдэг. Төлбөр төлөгч-хуулийн этгээд нь улсын төсвийн байгууллага бол гадаадад зорчих эрх

¹⁹¹ Өнөрцэцэг.Ч., УБ., 2020., Ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарт зориулсан гарын авлага., 83 дахь тал.

¹⁹² Мөн тэнд.

түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээг гүйцэтгэхгүй, улсын төсвийн байгууллагаас төлбөр гаргуулах үндэслэл¹⁹³, журмын дагуу гүйцэтгэнэ.

Төлбөр төлөгчийн гадаадад зорчих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн, зохицуулалт, журмын талаар авч үзье:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд "Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх" гэсэн нэр томъёо, албадлагын арга хэмжээ нь 1996 оны болон 2002 оны хуульд тусгагдаагүй бөгөөд 2002 оны "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль"-д сүүлд буюу шинээр 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр шинээр оруулж ирсэн албадлагын арга хэмжээний нэг юм.

2002 оноос өмнө манай улсын нийгэм эдийн засгийн байдлаас шалтгаалан хүн бүр гадаадад зорчих, цагаачлах, ажиллаж амьдрах асуудал бага гардаг байв. Иргэдийн хувьд гадаадад сурч боловсрох, арилжаа наймаа хийх зорилгоор түлхүү гадаадад зорчиж байсан бол 2001 оноос хойш Монгол улсын иргэд гадаад улсад ажиллах сонирхол их болсонтой холбогдуулан гадаадад зорчих иргэдийн тоо эрс нэмэгдсэн байна. 2003 оны байдлаар нийт 959.873 иргэн ажил, хөдөлмөр эрхлэх зорилгоор гадаад улсад зорчсон ба эдгээр тоо нь жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Төлбөр төлөгч иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч явуулдаг байсан бол 2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрх 133.4.4 дахь хэсэгт¹⁹⁴ "...Шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх..." гэж 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн өөрчлөлтөөр нэмсэн. Мөн энэ хугацаанаас буюу 2014 оны 12 дугаар сараас эхлэн төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлж эхэлсэн юм. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр Улсын Ерөнхий шийдвэр гүйцэтгэгч энэ албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульчилснаараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтэнд үр нөлөөтэй арга хэмжээ болсон гэж судлаачид үздэг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /2017/ 59 дүгээр зүйлд "Хуульд өөрөөр заагаагүй бол төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэхийг хориглоно" хэмээн заасан байна.¹⁹⁵ Энэхүү зохицуулалтаар шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрхгүй болсон ба Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4-т заасан "шүүхийн шийдвэр

¹⁹³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, УБ., 2017., Төрийн мэдээлэл эмхэтгэлийн №24., 93-р зүйл. 93.2 дахь заалт.

¹⁹⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2002 он. 133-р зүйл. 133.4.4. дэх заалт

¹⁹⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, УБ., 2017., Төрийн мэдээлэл эмхэтгэлийн №24.. 59-р зүйл. 59.1 дэх заалт

гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол шийдвэрт заасан хугацаагаар түдгэлзүүлэх” зохицуулалт хүчин төгөлдөр хэвээр үйлчилсээр байжээ. Энэ хугацаанд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааг хориглож, өмнөх хууль үйлчлэх үед гадаадад зорчих эрх түдгэлзүүлсэн “239,5



тэрбум төгрөгийн төлбөртэй Монгол Улсын 1569 төлбөр төлөгч, 20,5 тэрбум төгрөгийн төлбөртэй гадаад улсын 42 төлбөр төлөгчийн хилийн хоригийг цуцлах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан байна”.¹⁹⁶ Иймээс дахин хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулан одоогийн хэрэгжүүлж буй арга журмыг хуульчлан хэрэгжүүлэх болсон юм. Дээрх хуульд заасан үндэслэл бий болсноор мөнгөн төлбөр болон хөрөнгийн шинжтэй тодорхой үүргийг биелүүлэх хугацааг төлбөр төлөгчид тогтоож, биелүүлээгүй тохиолдолд үүсэх үр дагавар, холбогдох хуулийн зүйл, заалтыг тайлбарлан өгч мэдэгдэх хуудсаар мэдэгдэж ажиллахаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг томъёолсон юм.

Хүснэгт: 3 “Журмын харьцуулсан байдал”

Дээрх хүснэгтээс харахад “Төлбөр авагч хүсэлт гаргасан бол үнийн дүн харгалзахгүй” түдгэлзүүлэх үндэслэл хасагдсан байна. Мөн одоогийн мөрдөгдөж буй журамд төлбөр төлөгч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас түдгэлзүүлсэн шийдвэрийг цуцлуулахаар хүсэлт гаргах, хүсэлтэд холбогдох баримт, нотлогоог хавсаргах талаар тодорхой зааж өгсөн байна.

¹⁹⁶ Шийдвэр гүйцэтгэх албаны 2018 оны тайлан.

Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл болох шүүхийн шийдвэрт заасан мөнгөн төлбөрийн хэмжээ “Шүүхийн шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийж байгаа төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх журам”-д /2012/ 5.000.000 төгрөг, “Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, тоо бүртгэл хөтлөх журам”-д /2015/ журамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу тухайн үеийн дүнгээр 9.6 сая төгрөг, одоогийн хэрэгжиж буй журамд 50.000.000 төгрөгтэй тэнцэх хэмжээний төгрөг байхаар журамласан байгаа нь ихээхэн ялгаатай байдлыг илэрхийлж байна.

Мөн хүүхдийн тэтгэлэг төлөгч эхний 2 журамд мөн адил 6 сараас дээш хугацаагаар тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, тэтгэлгийн хуримтлал 1.2-2.2 сая төгрөгийн хэмжээтэй тэнцэх, 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн журамд 2023 оны амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээгээр бодоход 709.200-833.400 төгрөгийн хэмжээтэй тэнцэхээр бол гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх зохицуулалтай байжээ.

Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх албадлагын арга хэмжээг гадаадын зарим орнууд хэрхэн авч, хэрэгжүүлдэг талаар харьцуулан судалбал:

“Оросын холбооны улсын гүйцэтгэх ажиллагааны тухай хууль” /2007 он/-¹⁹⁷ Шийдвэр гүйцэтгэгчийн бүрэн эрхэд хариуцагчид хилийн хориг тавих эрхтэй бөгөөд хариуцагчийг Оросын холбооны Улсаас гарч түр хугацаагаар явахыг хязгаарлах хэмээн 67 дугаар зүйлд тусгаж албадлагын арга хэмжээг хуульд зааснаар болон шүүхийн шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлдэг байна.

1. Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр гаргасан гүйцэтгэх баримт бичиг болон гүйцэтгэх баримтын шинжтэй шүүхийн шийдвэрт заасан шаардлагуудыг хариуцагч тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн санаачлагаар буюу нэхэмжлэгчийн хүсэлтээр Оросын Холбооны Улсаас гарч явахыг түр хязгаарлах тухай тогтоол гаргах эрхтэй¹⁹⁸ гэжээ. Үүнээс үзэхэд Оросын холбооны улсын хувьд хариуцагч буюу төлбөр төлөгч шүүхийн шийдвэрт заасан нэхэмжлэлийн шаардлагыг тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн санаачилгаар болон төлбөр нэхэмжлэгчийн хүсэлтээр Оросын холбооны улсаас гарч явахыг түр хязгаарлах тухай тогтоол гаргах эрхтэйгээр хуульчлагдсан нь төлбөрийн үнийн дүн хязгаарлаагүй төдийгүй

¹⁹⁷ Оросын холбооны улсын гүйцэтгэх ажиллагааны тухай хууль.,2007., 67-р зүйл., Монгол, Орос, Солонгос улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл., 59 дахь тал.

¹⁹⁸ Оросын холбооны улсын гүйцэтгэх ажиллагааны тухай хууль.,2007., 67-р зүйл., Монгол, Орос, Солонгос улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл., 59 дахь тал.

шүүхийн шийдвэр заасан мөнгөн бус хэлбэрээр гаргасан шаардлага буюу нэхэмжлэлийн хувьд гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх боломжтой байна. Гадаадад хувийн хэргээр зорчих эрхийг түдгэлзүүлэхэд тус улсад хэр удаан байх ёстойг яг таг тогтоох боломжгүй, хугацааг тодорхойлох нь түүний төрөл, шалтгаанаас шалтгаалдаг тул зөвхөн хувь хүний асуудал юм. Тус улсын хууль тогтоомжид нөхцөл байдал бүрт заасан тодорхой хугацаа байдаггүй бөгөөд үүнийг шүүх эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэгч тогтоож, тогтоосон хугацааны хоригийг баримт бичигт тусгайлан заасан байдаг. 2008.01.29-ний өдрийн "Өртэй этгээдийг ОХУ-аас гарахыг түр хугацаагаар хязгаарлах тухай журам"-ын 2.3 дахь хэсэгт заасны дагуу "Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай" Холбооны хуульд¹⁹⁹ зааснаар "шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид 6 сарын хугацаанд өртэй улсын нутаг дэвсгэрээс гарахыг хязгаарлах талаар шийдвэр гаргаж болно" гэж заасан байна. Энэ хугацаанд төлбөр төлөгч нь мөнгөн төлбөр болон хөрөнгийн шинжтэй шаардлагыг биелүүлэх эсвэл дараагийн арга хэмжээ буюу шийтгэгддэг буюу та өрийг бүрэн төлөх хугацаатай байх болно, гэхдээ хэрэв үгүй бол хэргийг хянаж, шинэ шийдвэр гаргах ёстой²⁰⁰ гэх зарчим шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хэрэгждэг ажээ. Харин манай улсын хувьд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхдээ ямар нэгэн хугацаа заасан ойлголт байхгүй байна.


Оросын Холбооны улсад төлбөр төлөгч өөрийнхөө гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн эсэхийг мэдэх эрх нь нээлттэй байдаг. Төлбөр төлөгч нь цахим сангаас өөрийн мэдээллийг харах боломжтой байгаа нь төлбөр төлөгчид санхүүгийн хүндрэл учруулах цаашлаад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг төлбөрт орох эрсдэлээс давхар сэргийлэх зорилготойгоор хэрэгжүүлдэг байна.

Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн эсэхийг цахимаас дараах байдлаар татаж шалгах боломжтой байдаг.

1. Үндсэн цэснээс "Үйлчилгээ" -г сонгоно.
2. "Банк" хэсэгт очиж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дээр дарна .
3. Хайлтын аргыг сонгоно (IP дугаар, ID, хувь хүн эсвэл хуулийн этгээд).
4. Байгууллага бол нэр, хаяг, овог нэр, төрсөн огноог бичээд "хайх" товчийг дарна.

¹⁹⁹ Оросын холбооны улсын гүйцэтгэх ажиллагааны тухай хууль, 2007., 67-р зүйл., Монгол, Орос, Солонгос улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл., 59 дахь тал.

²⁰⁰ Как поехать за границу если приставы закрыли выезд (2023). www.youtube.com Үзсэн: 03.30.2023.,



/ Зураг: 1,2. ОХУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн вэбсайт /

Уг систем нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны дэлгэрэнгүй мэдээлэл, мөн эхлэх, дуусах хугацааг харуулдаг байна. Хэрэв та ямар нэгэн өр төлбөртэй байж, таны хилээр гарах эрхийг хориглосон эсвэл хориглох үндэслэлүүд арилсан ч таны хилээр гарах эрх сэргээгдээгүй байгааг харах боломжтой юм.²⁰¹

Манай Улсын хувьд Шийдвэр гүйцэтгэх албаны цахим хуудас 2021 онд шинэчлэгдэж дуудлага худалдаа, эрэн сурвалжлагдаж буй төлбөр төлөгч, цаг үеийн мэдээ, мэдээллийг байршуулсаны зэрэгцээ шийдвэр гүйцэтгэгчдийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэх эрх зүйн акт, тогтоолын маягтын загвар, сургалтын гарын авлага зэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээллийг нээлтэй ил тод шуурхай хүргэдэг боловч Оросын Холбооны Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн вэбсайттай харьцуулахад төлбөр төлөгч болон өмнө нь төлбөр төлөгч байсан этгээд нь хилийн хоригтой эсэхээ мэдэх боломжгүйгээс үүдэж ямар нэгэн байдлаар хохирч эргээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас учирсан хохирлоо нэхэмжлэх тохиолдол нилээдгүй байдаг билээ. Монгол улсын хэмжээнд 2018 онд программ хангамжийн шинэчилсэн хувилбарыг боловсруулж, 2014 оноос хойш үйл ажиллагаанд ашиглагдаж байсан “Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэлийн систем”-д бүртгэгдсэн мэдээллээр шинэ цахим сан үүсгэсэн “талууд” системээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүхэлд нь хянах²⁰²

²⁰¹ Жишээ №1:

ОХУ-ын цахим сайт мэдээллийн хэрэгслүүдээр “Улсаас гарахыг хориглосон эсэхийг шалгаж болно. Гадаадад аялахыг зөвшөөрсөн эсэхийг яаж мэдэх вэ. Тасалбарын мөнгө зарцуулагдсан хэрнээ өртэй байвал яах вэ?” зэрэг гарчиг бүхий нийтлэл хэд хэд харагдсан тул судлаас би сонирхон уншиж үзлээ. Ерөнхий гол утга санаа нь ямар тохиолдолд “ОХУ- аас гарахыг хязгаарладаг” талаар тайлбарласан ба тэдгээрийн аль ч тохиолдолд тухайн хил давах гэж этгээдэд тохиолдлож болохуйц зардал тийз, аялалын багц, зочид буудал, машин түрээсний зардал урьдчилан гарах алдагдалаас сэргийлэх боломжтой гэдгийг харуулсан байна. Холбооны шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба (fssp.russia). Гэх албан ёсны цахим сайтаас оршин суугаа газар, болон төрсөн огноо, нэр рд зэргээ оруулан дараа нь хайлт дээр дарж улсын хилээр чөлөөтэй зорчих эрхийг ямар хугацаатай түдгэлзүүлсэн талаар мэдээлэл өгдөг байна.

<https://el-in.ru/mn/investicii/otchet-po-proizvodstvennoi-praktike-v-fssp-otchet-po-praktike.html>

²⁰² Иргэн, захиргаа болон зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт., УБ., 2018., 4 дэх тал.

боложтой байдаг бөгөөд үүнээс төлбөр төлөгч гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн, сэргээгдээгүй байгааг мэдэх боломжтой юм.

Энэ нь талуудын тэгш эрхийг хангах мэдээлэл хүргэх, үйл ажиллагааг шуурхай явуулах зорилготой гүйцэтгэх баримт бичгийг цахим сангаас харах боломж боловч тус санд талууд нэвтрэх эрх, нууц үг олгогдож нэвтэрнэ. Энэ нь зарим тохиолдолд буюу ОХУ-ын туршлагатай харьцуулахад хязгаарлагдмал эх сурвалж аж.

Харин **Бүгд найрамдах солонгос улсын** Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх асуудлыг тусгайлан зохицуулаагүй, энэ нь шийдвэр гүйцэтгэгч шүүхийн харьяанд үйл ажиллагаа явуулдагтай холбоотой бөгөөд “Хэрэв өр төлбөртэй этгээд хилийн чанадад байгаа буюу байгаа газар нь мэдэгдэхгүй тохиолдолд гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой мэдэгдлийг хүргүүлэхгүй байж болно”²⁰³ гэж заажээ. Мөн “Гүйцэтгэх ажиллагааны явцад гадаад улсад мэдэгдэл хүргэх бол мэдэгдэлтэй хамт нэгэн зэрэг шүүхийн захирамж гаргаж, мэдэгдлийг БНСУ-д хүлээн авах газар, хүлээн авагчийг тайлагнах боломжит хугацааг тогтооно. Энэ хугацаанд тайлан ирээгүй бол аливаа нэмэгдэл мэдэгдлийг хүргүүлэхгүй байж болно”²⁰⁴ гэжээ. Үүнээс үзэхэд төлбөр төлөгч гадаад улсад зорчсон эсэхээс үл хамаарч хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг тасралтгүй явуулах боломжтой нь давуу тал болж буй юм.

Манай улсын хувьд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний үндсэн дээр гадаадад шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах буюу төлбөр төлөгч-иргэн хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан нь өөр оронд зорчиж, хаягийн бүртгэл байхгүйгээс ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалт тун хомс шүүхийн шийдвэрийг хэрхэн биелүүлэх нь тодорхойгүй байна.

Бүгд найрамдах Хятад ард улсын хувьд Хилийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу гадаад зорчих эрхийг түдгэлзүүлдэг бөгөөд иргэний хэрэг дуусгавар болоогүй тохиолдолд зөвхөн шүүхийн шийдвэрээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлдэг байна. Тус улсад “Social credit score” системээр үнэлдэг бөгөөд манай улсын адил мөнгөн шаардлага, үнийн дүн өндөр иргэдийг нэг жил хүртэлх хугацаанд зорчихыг хориглодог. Эдгээр улс орнуудын нийгмийн хөгжил, улс төр, эдийн засгийн байдал бас бус зүйлээс хамааран өөр өөр хэрэгждэг байна.

²⁰³ БНСУ-ын Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль. 2002., Монгол, Орос, Солонгос улсын шийдвэр гүйцэтгэлийн хуулиудын эмхэтгэл., 59 дахь тал.

²⁰⁴ Мөн тэнд.,

Швейцарь улс шүүхийн шийдвэрийг эсэргүүцсэн эсвэл оргон зугтах эрсдэлтэй гэх мэт хэд хэдэн үндэслэлээр зээлдэгчийн тус эрхийг түдгэлзүүлэхийг зөвшөөрдөг.

Ливан улсад зорчихыг хориглох /travel ban хэмээгддэг/ нь эсэргүүцлийн жагсаал зэрэг онц байдал бий болсон үед тус улсын төв банкнаас гарах мөнгөний урсгал, ихээхэн хэмжээний хөрөнгийн шинжтэй шаардлагаас гадна хилийн хориг хэт улс төрийн шинжтэй арга хэмжээний нэг ажээ.


Эдгээрээс үзэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд талууд нь аль болох зөвшилцөлд хүрэх, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр заавал биелэгдэх зэрэг зарчмын хэрэгжилт шийдвэрийн биелэлт хүртэл тодорхой цаг хугацааг хамарч, нэг нь нөгөөтэйгээ нөхцөлдсөн тодорхой үр дүнд чиглэсэн цогц ажиллагаа болох ёстой харагдаж байна.

Улсын хэмжээнд 50,0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 1.6 их наяд төгрөгийн төлбөртэй 2533 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаагаас 124.9 тэрбум төгрөгийн төлбөртэй 86 төлбөр төлөгч нэвтэрч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас зайлсхийсэн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан байна. Нийт хүүхдийн тэтгэлгийн мөнгийг 46.2 хувь буюу 5223 гүйцэтгэх баримт бичигт холбогдох тэтгэлэг төлөгч хүүхдийн тэтгэлгийн мөнгийг сар бүр төлөөгүй, зайлсхийсэн үйлдлийг тус тус гаргасан байна.²⁰⁵ Үүнээс үзэхэд хүүхдийн тэтгэлгээ 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тэтгэлэг төлөгчийн гадаад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг мөнгөн дүнгээр бодвол 2023 оны хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээ Улаанбаатар хотод 100 хувь нь 313.400 төгрөг хэмээн тооцоолоход 4 сар хүүхдийн тэтгэлэг төлөөгүй гэж бодоход 1.253.600 төгрөг, төвийн бүсийн хэмжээнд 100 хувь нь 272.300 төгрөг гэхэд 4 сарын тэтгэлэг 1.089.200 төгрөг зүүн бүсийн хэмжээнд 100 хувь 271.800 төгрөг гэхэд 4 сарын хүүхдийн тэтгэлэг 1.087.200 болж байна. Тэтгүүлэгч хүүхэд 11 насанд хүрээгүй бол Улаанбаатар хотод 626.800 төгрөг, төвийн бүсэд 544.600 төгрөг төлөөгүй байхад гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж болохоор байгааг харж болно.

Шийдвэр гүйцэтгэгч нараас “Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар болон хэрэгжилтэнд тулгамдаж буй зарим асуудлыг тодорхойлох, түүний шийдлийг эрэлхийлэх зорилгоор судалгаа авсан бөгөөд судалгаанаас дараах үр дүнг харж болно.

²⁰⁵ С.Бямба-Эрдэнэ., Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.,УБ., 2021., Иргэн захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн шинэтгэл илтгэлийн эмхэтгэлийн 266 дахь тал.


Асуулт 1: Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл буюу 50 саяас дээш төлбөрийн шаардлага орон нутаг болон нийслэлийн хэмжээнд хэр ялгаатай байгааг судалгаанд оролцогч нараар тодорхойлуулахад:



Хариулт 1: Судалгаанд нийт 70 шийдвэр гүйцэтгэгч оролцсоны 15 нь буюу 21.4% орон нутгийн харьяаллын, 55 нь буюу 78,6% нь нийслэлд харьяалагдах ба орон нутгийн нэгжид дээрх үндэслэлд хүрэх мөнгөн дүнгийн шаардлага бага гэх таамаглал дэвшүүлсэн


болно.

Асуулт 2: Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй субъектуудын ажлын ачаалал хэр байна вэ? Үүнээс хэдэн гүйцэтгэх баримт бичигт тус албадлагын арга хэмжээг хэрэгжүүлсэн бэ?



Хариулт 2: Судалгаанд оролцогчдын 32% буюу 1 шийдвэр гүйцэтгэгчид ойролцоогоор 100-150 гүйцэтгэх баримт бичиг, гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх ажиллагаа явуулаагүй” 52.9% буюу 1 шийдвэр гүйцэтгэгчид дунджаар 15 хүртэлх гүйцэтгэх баримт бичгийн мөнгөн дүн 50 саяас дээш буюу үлдсэн талаас илүү гүйцэтгэх баримт бичигт энэхүү ажиллагааг гүйцэтгэхгүй аж. Ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн тоо болон тус албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж буй тоо нь ихээхэн ялгаатай бага байгаа нь 50.0 сая төгрөг ба түүнээс дээш хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичиг гэж оруулж өгсөн нь харьцангуй зохицуулалт гэж үзэхээр байна.

Асуулт 8: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр 50 саяас дээш төгрөгийн төлбөртэй этгээдийн гадаадад зорчих эрхийг хязгаарлахаар зохицуулсан нь хэр оновчтой вэ?



шаардлагагүй, үнийн дүнг ихсгэх шаардлагатай гэж үзсэн байна.

Асуулт 7: Хүүхдийн тэтгэлгийг 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тэтгэлэг төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж байгаа нь хэр оновчтой зохицуулалт гэж үзэж байна вэ?

7. Хүүхдийн тэтгэлгийг 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тэтгэлэг төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж байгаа нь хэр оновчтой...рэв танд өөр санал байгаа бол доор бичнэ үү/
70 responses



Хариулт 7: Нийт оролцогчдын 75% буюу 53 нь оновчтой, 10% буюу 7 шийдвэр гүйцэтгэгч нь эрхзүйн зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай, 8,6% буюу 6 шийдвэр гүйцэтгэгч нь оновчтой зохицуулалт гэж үзсэн байна.

Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл, түүнийг өөрчлөх талаар санал байна уу? Хэмээн нээлттэй хариулах хэсэгт шийдвэр гүйцэтгэгчид өөр өөрийн саналаа үлдээсэн байна. Үүнд:

- Тогтоосон хугацаанд төлбөрийг төлөхгүй, биелүүлэхээс санаатай залсхийж байгаа тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч мөнгөн дүн хамаарахгүйгээр гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх саналыг гаргадаг байх нь оновчтой.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг 50 саяаас дээш төгрөгийн төлбөртэй этгээдийн эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг 20 саяаас дээш мөнгөн дүнтэй тэнцэх хэмжээний төлбөртэй этгээдийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, Хүүхдийн тэтгэлгийн 3 сараас дээш гэх хугацааг 6 сараас дээш болгох зохицуулалт шаардлагатай.

- Төлбөр төлөгчийн хувийн байдлыг харгалзан үзэж гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг уян хатан болгох ба сэргээх үндэслэл байгаа бол батлан даагч оролцуулан оргон зайлахаас сэргийлэх

- Түдгэлзүүлэхгүйгээр гадагш явуулснаараа төлбөр төлөгчийн төлбөрийн чадвартай болгоно гэж үзээд гадаадад байгаа төлбөр төлөгчид ажиллагаа явуулах эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох

- Хүүхдийн тэтгэлэг төлөгчийн хуримтлагдсан төлбөр буюу мөнгөн дүнгээс хамааран түдгэлзүүлэх нь оновчтой, хэрвээ тогтмол төлж байгаа тэтгэлэг төлөгч гадагш гарах бол 6 сарын тэтгэмжээ урьдчилан төлөх талаар нэмж зохицуулах шаардлагатай.

- Төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслийг нэмэх шаардлагатай, Хил хаасан, нээсэн даруйд шийдвэр гүйцэтгэгчид шууд мэдэгдэх

- Төлбөр төлөгчийн эд хөрөнгө, орлогыг бүрэн тогтоох шаардлагатай үл хөдлөх хөрөнгөөр баталгаа гаргаад түр хугацаагаар хилийн хоригийг нээдэг байвал төлбөр төлөх боломж илүү бүрдэх байх, төлбөр төлөгч гадаадад гарсан тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг түдгэлзүүлэхгүйгээр төлбөр төлөгчийг албадан авчирах, эрэн сурвалжлах ажиллагааг сайжруулах гэх мэтээр төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч талаар шийдвэр гүйцэтгэгч нар өөр өөрийн саналаа илэрхийлсэн байгаа юм. Зарим нэг утгаараа тус саналууд нь хэт нэг талыг баримталсан байж болзошгүй.

Дүгнэлт

Олон улсын хэмжээнд нийгэм, цаг үе өөрчлөгдөхийн хэрээр нарийн төвөгтэй хэвээр байсаар байгаа хүний аялал жуулчлал, цагаачлах, гадаадад хувийн хэргээр зорчих эрхийг хязгаарлах тэр дундаа өртэй этгээд буюу төлбөр төлөгчийн эрхийн хязгаарлалт нь ихээхэн өргөн цар хүрээг хамарсан асуудал билээ.

“Монгол Улсын иргэдийн чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрхийг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан нь хүний хувийн эрх чөлөөний нэг чухал хэлбэр бөгөөд хүн бүрт өөрийн аж амьдралаа аятай таатай зохион байгуулах, оюун санаагаа хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой эрх чөлөө”²⁰⁶ бөгөөд үүнийг хязгаарлаж буй үндэслэлүүдээс “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэр байгаа бол шийдвэр заасан хугацаагаар түдгэлзүүлнэ”²⁰⁷ гэж тусгасан зохицуулалт нь олон улсын эрх зүйн суурь хэм хэмжээгээр нийгмийн ёс суртахуун, дэг журмыг алдагдуулсан үндэсний аюулгүй байдалд харшилсан, бусдын эрхэнд халдсан зэрэг хүний эрхийг хязгаарлах стандартад нийцэж буйд маргах зүйл үгүй билээ гэвч хүний эрхийг хязгаарлах үндсэн буюу “түр зуурын шинжтэй, тэнцвэртэй байх” зарчимын агуулгыг шингээсэн төдий зохицуулалт өнөөгийн хэрэгжилт тулгамдаж байна хэмээн үзэж байна.

²⁰⁶ Совд.Г ... нар., УБ.,2000.,Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар.,125 дахь тал.

²⁰⁷ Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих цагаачлах тухай хууль., УБ.,1993., Төрийн мэдээдэл эмхэтгэлийн №2.,

Энэ нь хязгаарлалт тогтоосон хууль тогтоомжид хамаараад зогсохгүй мөн хуулийг хэрэгжүүлж байгаа субъектүүдын үйл ажиллагаанаас харагдаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх хугацаа заагаагүй нь цаашлаад төлбөр төлөгчийн эрх зүйн хариуцлагын асуудалтай холбогдох ба хөрөнгийн шаардлага тавин сая төгрөгийн үнийн дүн, хугацааны хувьд тэжээн тэтгэх үүргээ гурван сараас дээш хугацаагаар биелүүлээгүй гэх нөхцөлд эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн, хөрөнгөө нуун дарагдуулсан, төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор гадаад улсад оргон зайлж болзошгүй зэрэг үндэслэл байгаа нь харьцангуй тэгш бус хэрэгжилтээр илэрч байна.

Санал

1. Талууд программыг сайжруулж, мэдээллийн технологийг боловсронгуй болгох. Нэгдсэн санг илүү хүртээмжтэй байдлаар бий болгох буюу төлбөр төлөгчийн түдгэлзүүлсэн гадаадад зорчих эрх сэргээгдэхгүй байх механик алдаанаас сэргийлэх, энэ нь эргээд тус хориг арга хэмжээний сөрөг үр дагавраас сэргийлэх боломжтой.

2. Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээг сайжруулан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх

Ингэснээр төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэхгүйгээр гадаад дахь орлогоос төлбөр төлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

3. Төлбөр төлөгч төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн, хөрөнгө, орлогоо нуун дарагдуулсан эсэх үндэслэлээр санал гаргаж байгаа тохиолдолд төлбөр төлөгчийн хаягандаа оршин суудаггүй, хаягаа өөрчилсөн боловч шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх үүргээ хэрэгжүүлээгүй, эд хөрөнгийн мэдүүлэг хуулийн хугацаанд гаргаагүй, худал мэдүүлсэн, тогтоох, баримтжуулах талаарх арга журмыг нарийвчлан тогтоож өгөх Шийдвэр гүйцэтгэх газар хэлтэс бүр өөр өөрөөр хэрэгжүүлэх, цаашлаад шийдвэр гүйцэтгэгч бүр өөр өөрөөр тодорхойлох явдал түгээмэл байгааг халах

4. Төлбөр төлөгчид түүний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх талаар мэдэгдэх, ямар үндэслэлээр санал оруулж буйгаа тодорхой тусгах, Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн тогтоол гармагц төлбөр төлөгчид танилцуулж баримтжуулах зэрэг ажиллагааг цаг алдалгүй хийж гүйцэтгэх шаардлагатай.

5. Төлбөр төлөгчийн төлбөрийн шаардлага 50 сая болон хүүхдийн тэтгэлэг төлөгчийн төлбөрийн шаардлага хоорондын зөрүү 50 дахин ялгаатай байгаа ялгаатай байдлыг арилгах нь хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байх эрхийг хангахад тустай.